Ус гэрэлт ирээдүйн төлөө



ХОТ, СУУРИНЫ ҮС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2014

www.wsrc.mn

Эрхэм зорилго

Монгол улсад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн чанар, стандарт бүхий найдвартай, тэгш, хүртээмжтэй үйлчилгээг баталгаажуулах оновчтой зохицуулалтыг хийхэд оршино.

Стратегийн зорилтууд:

Зохицуулах зөвлөл нь эрхэм зорилгынхоо хүрээнд дараах дурдсан стратегийн зорилтуудыг хэрэгжүүлнэ.

ЗОРИЛТ 1

Хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах,бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх үйлчилгээг чанартай, найдвартай хүргэхэд чиглэгдсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж, аливаа шийдвэрийг шинжлэх ухаанчаар, тооцоо, судалгааны үндсэн дээр, оролцоонд тулгуурлан гаргана.

ЗОРИЛТ 2

Зохицуулах зөвлөл,түүний үйл ажиллагаагааг төрийн бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн, хараат бус байдлаар мэргэжлийн түвшинд явуулах, зөвлөлийг бэхжүүлэх

ЗОРИЛТ 3

Цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ тарифыг бодит зардалтай нь уялдуулан, хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах зарчимд үндэслэн, хангагч байгууллагуудыг зах зээлийн орчинд үр ашигтай түвшинд тогтоох

ЗОРИЛТ 4

Хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх замаар усны үйлчилгээний менежментийн шинэ арга хэлбэрүүдийг нэвтрүүлж, хэрэглэгчийг дээдэлсэн үйлчилгээний салбар болгох

ЗОРИЛТ 5

Чиг үүргийнхээ дагуу мэдээллийн сан байгуулах, мэдээллийн 2 талт идэвхтэй, хариуцлагатай урсгалыг бий болгох, олон нийтэд нээлттэй ил тод ажиллах.

ЗОРИЛТ 6

Шинжлэх ухааны мэдээлэл, дэвшилтэт арга технологийг уламжлалт зан үйл, ёс суртахууны хэм хэмжээгээр баяжуулан ашиглах, салбарын мэргэжилтнүүдэд

Гарчиг

Оршил

1. **Хуулийн хэрэгжилт:**

-Үнэ тариф...../2-4/

-Тусгай зөвшөөрөл...../5-9/

2. **Судалгаа, дүн шинжилгээ** ...../10-12/
3. **Сургалт хөгжлийн чиглэл** ...../13-14/
4. **Хэвлэл мэдээллийн чиглэл**...../14-15/
5. **Гадаад болон дотоод хамтын ажиллагаа** ...../15-17/
6. **Дүгнэлт** ...../18/

Хүснэгт

1. **Хүснэгт-1** /Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төрөл/ ...../5/
2. **Хүснэгт-2, 3** /Гүйцэтгэлийн үзүүлэлт/ ...../11-12/
3. **Хүснэгт-4** /Гадаад харилцаа, сургалт/ ...../15/

Зураг

1. **Зураг-1** /Тусгай зөвшөөрөл сунгуулсан төрөл/ ...../5/
2. **Зураг-2** /Тусгай зөвшөөрөл шинээр олгосон төрөл/ ...../5/

ОРШИЛ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж,ариутгах татуургын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт зааснаар Зохицуулах Зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөрөө ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй бөгөөд мөн хуулийн 10 дугаар зүйлд заагдсан бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Зохицуулах зөвлөл Монгол улсад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн чанар стандарт бүхий найдвартай, тэгш, хүртээмжтэй үйлчилгээг хот, суурины хэрэглэгчдэд хүргэх, баталгаажуулах оновчтой зохицуулалтыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

1. Хуулийн хэрэгжилт

Усны үнэ цэнэ ба хэрэглэгч хангагчийн эрх ашгийг тэнцвэртэйгээр хамгаалах нь

1.1. Хуулийн 10.1.1 дэх заалт буюу цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр тогтоох аргачлал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх ажлын хүрээнд:

Зохицуулах зөвлөлөөс Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар /ШӨХТГ/-ын 2014 оны 1 дүгээр сарын 14-ний хурлаар Нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын санхүү, эдийн засгийн байдал, хүндрэлийн талаар танилцуулга хийн тариф өөрчлөх санал хэлэлцүүлсэн боловч тодорхойгүй шалтгаанаар хойшлуулсан билээ.

Улмаар 6 сард тус байгууллагын 07 тоот тогтоолоор Улаанбаатар хот болон, Төв аймаг, алслагдсан Багануур, Налайх дүүргүүдийн цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ тарифыг өөрчлөх зөвшөөрөл олгосон болно. Иймд Зохицуулах зөвлөл нь бүрэн эрхийнхээ дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас тарифын судалгаа, тооцоог шинэчлэн авч байгууллагын "Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ"-г /цаашид БОш/ тогтоон, бөөний үнийг Зохицуулах зөвлөлийн 2014 оны 07-р сарын 09-ны хурлаар хэлэлцэн батлав.

Түүнчлэн суурь хураамж нэвтрүүлэхтэй холбогдуулан "Суурь хураамж мөрдөх заавар"-ыг боловсруулан батлав. Хангагч байгууллагуудын БОш тогтоохдоо зардлыг хянан, үндэслэлгүй өсгөсөн зардлыг бууруулах замаар бодит зардалд суурилсан, хамгийн бага өртгийн зарчмыг баримтлан ажилласан бөгөөд дийлэнх байгууллагын элэгдлийн санг үйлчилгээний тарифт тусгав.

Улаанбаатар хот, Төв аймагт суурь хураамж нэвтрүүлэн, тариф нэмснээр УСУГ болон Нийслэлийн болон Төв аймгийн хангагч байгууллагуудын хүлээгдэж байсан алдагдлыг 4-5 тэрбум төгрөгөөр бууруулж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах бололцоог бүрдүүллээ.

Түүнчлэн 21 аймаг, орон нутгийн хангагч 34 байгууллагын үйлчилгээний тариф нэмэх саналыг шинэчлэн, хянан боловсруулж Өрсөлдөөний тухай хуулийн 6.2 дах заалтын дагуу зөвшилцөхөөр ШӨХТГ-т 14 оны 5, 7, 10 сард тус тус хүргүүлж, 2014 он гэхэд тус байгууллагад үнэ тарифын асуудлаар нийт 8 удаа хандсан байна.

Ийнхүү Зохицуулах зөвлөлөөс ШӨХТГ-т үнэ тарифын санал хүргүүлэх тухай бүрт аймаг орон нутгийн ТЗЭ-дээс саналыг дахин авч, тооцоо судалгааг шинэчилж, хянах, боловсруулах ажлыг гүйцэтгэж байв. Үнийн саналыг байгууллага тухайн жилд зардлаа нөхөхүйц

буюу аль болох түүнд ойртохуйц түвшний тариф тогтоох, элэгдлийн зардлыг 70 хүртэл хувиар байгуулах боломжтой тариф тогтоох гэсэн 3 хувилбараар боловсруулж байгаа бөгөөд хувилбар тус бүрийн тооцоо судалгаа, нөлөөллийн шинжилгээг хийсэн болно.

Мөн 2014 онд үнэ тариф өөрчлөх асуудлыг олон нийтэд хүлээн зөвшөөрүүлэх ажлын хүрээнд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний тарифыг өөрчлөх зайлшгүй шаардлагыг хэрэглэгчид, шийдвэр гаргагчдад танилцуулах, сурталчлах ажлыг тасралтгүй зохион байгуулсны үр дүнд 2014 оны 11-р сард ШӨХТГ-аас аймаг орон нутгийн үнэ тариф өөрчлөх зөвшөөрөл авч, ТЗЭ-дийн 2015 оны төлөвлөгөө, 2014 оны гүйцэтгэлд үндэслэн усны үйлчилгээний тариф шинэчлэх ажлыг эхлээд байна.

2014 оны эцсийн байдлаар 69 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын БОш, тарифыг шинэчлэн баталж, суурь хураамжийг мөрдүүлэхээр Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэв. Хангагч байгуулагуудын үйлчилгээний тарифыг нэмж, суурь хураамж мөрдүүлснээр 2015 онд алдагдал 6 гаруй тэрбум төгрөгөөр буурч ихэнх байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бүрдэх юм.

Түүнчлэн ТЗЭ-ээс ирүүлсэн үнэ тарифын саналыг хянах явцад илүү төлөвлөж хий өсгөсөн зардлыг хянаж бууруулсны дээр зөөврийн усны үнийг хэвээр үлдээн, зөвхөн төвлөрсөн шугамд холбогдсон хэрэглэгчийн тарифыг өсгөх бодлого баримтлан ажиллалаа. Бохир усны үнэ тариф шийдвэрлэх ажлын хүрээнд УСУГ-ын “Харгиа” урьдчилан цэвэрлэх байгууламжид /УЦБ/ мөрдөх тариф тогтоох зорилгоор 3 байгууллагын хамтарсан ажлын хэсэг ажиллаж туршилтын үр дүн, тооцоо судалгаанд үндэслэн УЦБ-д мөрдөх бохир усны үйлчилгээний түр тарифыг тогтоох асуудлыг 1-р сарын 28-ны өдрийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Дээрх туршилтын үр дүнг харахад тус УЦБ-ийн технологийн горим алдагдсанаас арьс, ширний үйлдвэрүүдийн бохир усыг стандартын түвшинд хүртэл цэвэршүүлж чадахгүй байгаа тул цаашид байнга мөрдөх

2014 онд 69 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын БОш, тарифыг шинэчлэн баталж, суурь хураамжийг мөрдүүлэхээр Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэв.

бохир усны үйлчилгээний тариф тогтоох боломжгүй гэсэн дүгнэлт гарсан тул энэхүү дүгнэлтэд тулгуурлан Зохицуулах зөвлөлөөс УЦБ-д технологийн горимын тохируулга хийх, цаашид шаардлагын дагуу ажилладаг болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж, шаардлагыг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлэв. Улмаар түр тарифын үйлчлэх хугацаа дуусан тул УСУГ-аас тариф тогтоолгох хүсэлтээ дахин ирүүлсэн тул тариф хүчингүй байсан 2-6 саруудад УЦБ-ийн ажилласан зардлыг нөхөх асуудлыг Зөвлөлийн хурлаар шийдвэрлэлээ. Зохицуулах зөвлөлөөс Монголын арьс, шир үйлдвэрлэгчдийн холбоо, УСУГ-ын төлөөлөл орсон ажлын хэсэг байгуулан цаашид УЦБ-ын үйл ажиллагаагааг жигдрүүлэх, технологийн шаардагдах түвшинд ажиллах хүртэл мөрдөх түр тариф тогтооход шаардагдах бодисын нормт хэмжээг тогтоосон болно.

Үүний үндсэн дээр "УСУГ"-ын УЦБ-ын үйлчилгээний тарифыг саналыг дахин хянаж, Зөвлөлийн 11 дүгээр хурлаар хэлэлцүүлэн 29 дүгээр тогтоолоор батлав. Ингэснээр УЦБ-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл хангагдав.

1.2 Хуулийн 10.1.2 дах заалт буюу үндсэн хөрөнгийн элэгдэл,хорогдлын шимтгэлийн хэмжээг тогтоох ажлын хүрээнд:

Тарифын тогтолцоог шинэчилж,суурь хураамж нэвтрүүлсэнтэй холбогдуулан Зохицуулах зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг хангуулах үүднээс шинэчилсэн тарифыг хэрэгжүүлэх, мөрдүүлэх талаар удирдамж боловсруулан 9-р сард хангагч 47 байгууллагад хяналт шалгалт явуулав. Хийгдсэн шалгалтын дагуу нэгдсэн тайлан гаргаж, шалгалтанд хамрагдсан нийт

47 ТЗЭ болон "УСУГ"-ын санхүүгийн байдалд анхан шатны үнэлгээ өгч, шаардлагатай зарим газруудад албан тоотоор зөвлөмж, шаардлага хүргүүлэв.

Хангагч байгууллагууд зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн, зөрчил дутагдлыг арилгасан тухай тайлан мэдээг ирүүлсэн болно.

Хэрэглэгчдээ дээдэлсэн чанартай үйлчилгээний төлөө

1.3 **Хуулийн 10.1.3 заалт буюу Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох ажлын хүрээнд:**

• Хэрэглэгчдийн гомдол, мэдээллийг үндэслэн тусгай зөвшөөрлийн хугацаа нь дуусан буюу бохир усыг тусгай зориулалтын машинаар соруулах үйлчилгээ, гүний худгаас ус олборлон иргэдэд борлуулах ус хангамжийн үйлчилгээг зөвшөөрөлгүйгээр эрхэлж буй 21 аж ахуйн нэгж байгууллагуудыг илрүүлэн, хуулийн дагуу мэдэгдэл хүргүүлэв. Мэдэгдлийн дагуу холбогдох байгууллагуудад ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын зөвшөөрөл олгох ажлыг зохион байгууллаа.

• Ус хангамжийн ашиглалт, үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох, сунгах,түдгэлзүүлэх, хүчингүй болгох бүрдэл материалуудыг тухай бүр хүлээн авч хянан, 50 гаруй байгууллагын зөвшөөрлийг /зураг-1/ сунгах болон /зураг-2/ шинээр олгох асуудлыг Зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэв.



Зураг-1

Зураг-2

- Хангагч байгууллагуудын зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралт, тогтоолын төсөл, тусгай зөвшөөрлийн ангилал, байгууллагын удирдлага, хаяг, утас, бүртгэлийн судалгааг тухай бүрд шинэчилсэн.

2014 оны 12-р сарын 03 -ны байдлаар ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй /хүснэгт 1/ нийт 122 байгууллага байна.

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигчид

Хүснэгт-1

№		тоо хэмжээ	ДҮН XII/3
1	**Нийслэл аймаг,орон нутгийн НАА байгууллага:**		42
	Төрийн өмчит	1	
	Нийслэл,орон нутгийн өмчит	27	
	Хувийн хэвшлийн	6	
	Бусад	8	
2	**Орон сууц ашиглалтын үйлчилгээ:**		52
	Нийслэлийн өмчит	3	
	Хувийн хэвшлийн	47	
	Бусад ТББ	2	
3	Бохир усыг тусгай зориулалтын машинаар соруулах үйлчилгээ		17
№	**Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төрөл**	тоо хэмжээ	ДҮН XII/3
4	Туршилт тохируулга хийх үйлчилгээ		1
5	Цэвэрлэх байгууламжийн ашиглалт,засвар үйлчилгээ		1
6	Ус цэвэршүүлэн савлах		9
	Нийт		122

1.4 Хуулийн 10.1.4 заалт буюу Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах:

• Зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахаар материал ирүүлсэн 50 байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцах, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хяналт биелэлтэд хяналт шинжилгээ хийх зорилгоор удирдамжийн дагуу нийслэл болон хөдөө орон нутагт ажиллав. Үүнд Архангай, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Төв, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Хэнтий, Сэлэнгэ, Сүхбаатар зэрэг 21 аймгийн 41 байгууллага багтсан бөгөөд үндсэн үйл ажиллагаа, ус хангамж, цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал, хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд шинжилгээ хийлээ.



Ажлын хэсэг хангагч байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн чадавхид дүн шинжилгээ хийж, мэргэжлийн дүгнэлт гарган ажиллав. Ажлын явцад усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламжийн судалгааг шинэчлэн, мэдээллийн санг баяжуулж, холбогдох норм, дүрэм, стандартын биелэлт ямар түвшинд байгааг тогтоож, шаардлагатай тохиолдолд мэргэжил арга зүйн зөвөлгөөгөөр хангав.
• Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын 2013 оны үйл ажиллагааны тайлан мэдээг боловсруулж, гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг дүгнэж 2014 оны 1-р сар дБХБЯаманд хүргүүлэв.

• Судалгааны тоо баримтад үндэслэн байгууллагын санхүү эдийн засгийн чадамж сул, үйлчлүүлэгч өрхийн тоо зардлаа нөхөх түвшинд хүрэхгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нөхцөл шаардлагыг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлсний дагуу "Монватер ХХК, "БЧГ" ХХК, "Тохилог шинэ ертөнц" ХХК, "Морьттүнгэ" ХХК, "Гантус-Өргөө" ХХК

зэрэг байгууллага техник, технологийн болон менежментийн үйл ажиллагаагаа өргөтгөв.

• Зөвшөөрөл эзэмших, сунгуулахаар хүсэлтээ ирүүлсэн 60 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын материал бүрдүүлэлтийг хянаж, зөвөлгөө өгөв.

• Зөвшөөрлийн хугацаа дуусан, удаа дараа үйл ажиллагаа нь доголдож, хэрэглэгчдийг хохироосон "ЖМБО" ХХК, "Хаш-Эрдэнэ" ХХК-ыг хэрэглэгчдийн гомдлын дагуу шалгаж, улсын байцаагчийн мэргэжлийн дүгнэлт гаргуулж асуудлыг хуулийн дагуу Нийслэлийн МХЕГ-т шилжүүлэв.

• Зарим орон нутагт ус хангамж, ариутгах татуургыг хөгжүүлэх дорвитой бодлого үгүйлэгдэж, Нийтийн аж ахуйн байгууллагуудын үйл ажиллагааг орон нутгаас дэмжиж ажиллах талаар хангалтгүй байна. Тухайлбал орон нутагт ундны усны эрүүл ахуйн дэглэм алдагдсан, хамгаалалтын бүс зөрчигдсэн зэргээс болж хүн амын ундны усны аюулгүй байдал эрсдэлтэй түвшинд орсон. Иймд усны чанарын хяналтыг сайжруулах, хууль, дүрэм, журмын хэрэгжилтийн хяналтыг хангуулах зайлшгүй шаардлагатай уялдуулан

"Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-д нэмэлт, өөрчлөлт оруулаа.

• Тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй 2013-2014 онд байгуулсан гүйцэтгэлийн гэрээг дүгнэж, гэрчилгээний хавсралтад тэмдэглэгээ хийж, баталгаажуулав. Гүйцэтгэлийн гэрээнд өөрчлөлт оруулж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хавсралтаар дүгнэж, оролцогч талуудын эрх үүргийг шинэчлэн боловсруулав.

1.5 Хуулийн 10.1.5 заалт буюу Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх ажлын хүрээнд:

• Зөвшөөрөл шинээр авах, сунгуулах хүсэлт гаргасан, судалгааны мэдээ, материал хүргүүлэх тухай, холбогдох дүрэм, журамд санал авах тухай нийт 569 албан бичиг ирсэн бөгөөд Монгол улсын иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай хуулийн дагуу шуурхай шийдвэрлэн, холбогдох арга хэмжээг авч, 551 хариу албан тоотыг хүргүүлэв. Тухайлбал Сэлэнгэ аймгийн "Алтанбилэг" ХХК-ийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, мэргэжлийн дүгнэлт гаргаж аймгийн ИТХ-ийн дарга, Засаг дарга, сумын Засаг дарга нартай хамтран зөвшилцөж, Мэргэжлийн хяналтын газарт хандсаны үр дүнд орон нутгаас Алтанбулаг сумын 6 байрны цэвэр, бохир усны шугам сүлжээг шинэчлэн солив.

• Орон сууц ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "ОНЕА" ХХК-ийн үйл ажиллагаа нь доголдож, оршин суугчдыг хохироосон өргөдлийн дагуу тус компани дээр ажиллаж, хугацаатай үүрэг даалгавар өгч, зохих арга хэмжээг авав.

• БЗДүүрэгт байрлалтай "Тохилог сууц" СӨХ нь хууль зөрчиж, зөвшөөрөлгүйгээр орон сууц ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ тарифыг батлагдсан хэмжээгээр бус дур мэдэн тооцож байсныг илрүүлж, дүгнэлт гарган зохих шатны байгууллагуудад мэдэгдэл хүргүүлэв. "Ундны усны цоргоноос зэвтэй ус гардаг" өргөдлийн дагуу "Вива сити" хотхоны ашиглалтыг хариуцдаг Санкомфорт" ХХК-ийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай танилцаж, доголдлыг арилгуулав.

• Налайхын дулааны станцаас ирүүлсэн гомдлын дагуу "Чандмань-Налайх" НӨҮГ нь үйлчилгээний тарифыг өөрчлөөгүй боловч хууль зөрчин дахин

баталсныг илрүүлж, зөрчлийг арилгуулав.

• Түүнчлэн УСУГ-ын төлбөр тооцоотой холбоотой 30 гаруй хүсэлт, гомдол ирснийг судалж, шийдвэрлэн, УСУГ-т зөвлөмж, албан даалгавар хүргүүлэн ажиллав.

• УБТЗ-ын даргын тушаалаар үнэ тариф өөрчилсөн байсныг хууль бус хэмээн үзэж уг тушаалыг хүчингүй болгох тухай Улсын байцаагчийн дүгнэлт, албан шаардлага хүргүүлэв.

• НМХГ-ын 2014.05.13-ны өдрийн 02-02/229 тоот "Хувийн хэвшлийн орон сууцны компаниудын төлбөр тооцоонд ашиглаж байгаа хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, ашиглалт, хэмжлийн нэгдмэл байдалд хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн дагуу НМХГ-тай хамтарсан шалгалтын хэсэгт ажиллан, холбогдох тайлан, дүгнэлтийг МХГ-т хүргүүлэв.

Ус ашиглалт, ариутгах татуургын улсын байцаагчийн ажлын хүрээнд:

Нийтийн аж ахуйн салбарт мэргэжлийн хяналтыг хамтран хэрэгжүүлэх, салбарын хүрээнд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран ажиллах гэрээг 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдөр байгуулав.

Гэрээний дагуу МХЕГ-ын даргын 277 тоот тушаалаар ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагчийн "65-07-001" дугаарт эрхийг Зохицуулах зөвлөлийн ахлах мэргэжилтэн, мэргэшсэн инженер Г.Нарантуяад олгов.

Нийтийн аж ахуйн салбарт мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтэнд хяналт тавих ажлын хүрээнд:

• Баянзүрх дүүргийн 14-р хорооны 82-р байрны оршин суугчдаас ирсэн гомдлын мөрөөр шалгахад байрыг барьсан БНХАУ-ын хөрөнгө оруулалттай "Ньюдьюрал" ХХК нь зөвшөөрөлгүйгээр орон сууцны ашиглалтын үйл ажиллагаа явуулж, оршин суугчдаас цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрийг аж ахуйн нэгжийн тарифаар тооцон нэхэмжилж хууль зөрчсөн нь тогтоогдсон болно. Иймд хуулийн дагуу тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх хугацаатай үүрэг даалгаврыг тус байгууллагад өгч, улмаар "Азын завод" ХХК-д шилжүүлснээр үйлчилгээний чанарын талаар тавьсан оршин суугчдын гомдлыг шийдвэрлэв.





1.6 Хуулийн 10.1.6 заалт буюу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрчлөн зохион байгуулагдах, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг шинэчлэх, эд хөрөнгөө барьцаалах нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд нөлөөлөхөөр бол тухайн өөрчлөлтийг зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэх ажлын хүрээнд:

• Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10.1.6 дах заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн өмчит "ус хангамж, ариутгах татуурга, орон сууц, нийтийн аж ахуйн ашиглагч байгууллагыг нэгдсэн удирдлагаар хангах, найдвартай ажиллагаа, тогтвортой байдлыг хангуулах" ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Зохицуулах зөвлөлөөс 2 ажилтан ажиллав. Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 69-р тоот "Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг өөрчлөн байгуулах тухай" тогтоолын дагуу 21 ОНӨҮГ-ыг татан буулгаж,"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар"ын "Хэрэглэгчдэд үйлчлэх төв" болгон үйлчлэх хүрээ, хүчин чадал, санхүүгийн чадавхийг нь харгалзан өөрчилж, олон улсын туршлагаар нэг худалдан авагчтай зах зээлд шилжүүлсэн.

Тус өөрчлөн байгуулалттай холбоотойгоор Зохицуулах зөвлөлийн хурлын 51-р тогтоолоор ОСНААУГ-т шинээр тусгай зөвшөөрөл олгож, борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг /БОш/тооцсоны үндсэн дээр тарифыг шинэчлэн батлав.

1.7 Хуулийн 10.1.7 дах заалт буюу тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах ажлын хүрээнд:

• Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс жил бүр тайлан мэдээ авч нэгтгэсний үндсэн дээр хүний нөөц, барилга байгууламж, шугам сүлжээ, техник тоног төхөөрөмжийн талаарх мэдээллийг нэгтгэснээс гадна 2012-2014 санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдийг нэгтгэж мэдээллийн нэгдсэн санг үүсгэв. Цаашид цахим хуудсанд байршуулж мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллахаар төлөвлөөд байна.

• Нийслэлийн хэмжээнд бохир ус зөөвөрлөдөг машинуудын талаар мэдээлэл цуглуулж, судалгаа гаргав.

1.8 Хуулийн 10.1.9 дэх заалт буюу техникийн нөхцөл олгох журам батлах ажлын хүрээнд:

Ус хангамж, ариутгах татуургын “Техникийн нөхцөл олгох журам”-ыг боловсруулж, бүрдлийг ханган ХЗЯ-ны улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлээд байсныг 2014.03.11-ны өдөр Улсын нэгдсэн бүртгэлийн 3438 дугаарт бүртгүүлэн, Legalinfo.mn цахим сайтад нийтлүүлсэн бөгөөд салбарын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

2. Сайн судалгаа эөв шийдвэр гаргахын үндэс юм

Нийтийн аж ахуйн байгууллагуудын санхүүгийн чадавхийг сайжруулах зорилтын хүрээнд үйлчилгээний өртөг зардлын шинжилгээ, тарифын тооцооллын судалгааны ажлуудыг үргэлжлүүлж байна. Үүнд:

- Цэвэр усны тариф, бохир усны төлбөр тооцох аргачлалыг боловсронгуй болгон шинэчлэх төсөл боловсруулав.
- Хэрэглэгчдэд үзүүлэх нөлөөллийн шинжилгээг **Улаанбаатар хот, Налайх, Багануур дүүрэг, 21 аймаг тус бүрээр** хийж, ШӨХТГ болон холбогдох байгууллагуудад хүргүүлэв.
- Түүнчлэн ТЗЭ байгууллагуудын 2013 оны санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн дүгнэлт гаргаж, БХБЯ-нд хүргүүлэв.
- НҮБХХ-ийн "Хөдөөгийн УХАТ" төслийн судалгааны материал баримтуудад түшиглэж орон нутгийн түвшинд үйлчилгээний үнэ тарифыг тогтоох талаар төслийн зөвлөхүүдтэй хамтран ажиллаж байна. Мөн ШӨХТГ-тай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд холбогдох мэргэжилтнүүдтэй судалгааны материал дээр санал солилцож, Зохицуулах зөвлөл тарифыг сумдын түвшинд бие даан шийдвэрлэх нь зүйтэй гэсэн шийдэлд хүрэв.
- Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор

"Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт"-ийг боловсронгуй болгож, ОСНАА-н 21, орон нутгийн 32 байгууллагын техник, технологи, хүний нөөц, санхүүгийн үндсэн үйл ажиллагааг дүгнэж, 2013 оны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг /хүснэгт-2, хүснэгт 3/ боловсруулж, олон нийтэд мэдээлэв.

Хүснэгт-2

	Гүйцэтгэлийн үзүүлэлт		Хэмжих нэгж	Гүйцэтгэлийн үзүүлэлтийн статус		
				Ногоон	Шар	Улаан
1	Орлого болоогүй ус NRW	Хөдөө орон нутаг	%	=<18	18<... <40	40=<
		ОСНААУГ-УБ		=<8	8<... <15	15=<
2	Орлогын 1 төгрөгт ногдох зардал		Төг	=<0.9	0.9<... =<1.2	1.2<
3	Борлуулсан 1 м3 усанд ногдох үйл ажиллагааны зардал	Хөдөө орон нутаг	Төг	=<750	750<... =<1750	1750<
		ОСНААГ-УБ		=<330	330<... =<500	500<
4	1м3 усанд ноогдох эрчим хүчний зардал	Хөдөө орон нутаг	Төг	=<170	170<... <350	350=<
		ОСНААГ-УБ		=<15	15<... <28	28=<
5	Тоолууржилтын түвшин	Хөдөө орон нутаг	%	100=	70=<... <100	70<
		ОСНААГ-УБ		100=	50=<... <100	50<
6	Мэргэжилтэй боловсон хүчин		%	70=<	50=<...<70	<50

Хүснэгт-3

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд	Орлого болоогүй ус	Орлогын нэг төгрөгт ногдох зардал	Борлуулсан 1м^3 усанд ноогдох ҮАЗ	1м^3 ус дамжуулан түгээх эрчим хүчний зардал	Тоолууржилт	Боловсон хүчин
1	"Ундарга" ХХК	ногоон	шар	шар	шар	шар	улаан
2	"Чандмань Баянхонгор" ХК	улаан	шар	шар	ногоон	улаан	шар
3	"Суат" ХХК	улаан	улаан	шар	шар	улаан	улаан
4	"Булган мээж" ХХК	улаан	ногоон	улаан	шар	шар	улаан
5	"Ундарга-Алтай" ОНӨҮГ	улаан	шар	шар	шар	улаан	ногоон
6	"Ус-Ду" ОНӨҮГ	ногоон	улаан	шар	шар	шар	шар
7	"Дархан ус суваг" ХК	улаан	улаан	ногоон	улаан	шар	0
8	"Дулаан шарын гол" ХХК	шар	шар	ногоон	ногоон	улаан	улаан
9	"Эмтнаран" ОНӨААТҮГ	ногоон	шар	шар	шар	улаан	шар
10	"Чандмань Илч" ХХК	улаан	шар	улаан	улаан	ногоон	ногоон
11	УБТЗ-ын "ЭХУХ-н 2-р анги»	ногоон	шар	шар	ногоон	улаан	улаан
12	"Дундговь ус" ХХК	улаан	улаан	улаан	улаан	ногоон	улаан
13	"Дорнод НАА" ХХК	улаан	шар	шар	шар	шар	ногоон
14	"Амь-Ус" ХХК	улаан	шар	улаан	шар	улаан	улаан
15	"Урсгал ус" ХХК	шар	шар	улаан	улаан	улаан	ногоон
16	"Цант-Орхон" ХХК	0	шар	0	0	улаан	шар
17	УБТЗ-ын "ЭХУХ 1-р анги"	ногоон	улаан	улаан	ногоон	улаан	шар
18	"Гавшгай ус" ХХК	шар	шар	шар	улаан	улаан	ногоон
19	"Эрдэнэт-Ус ДТС" ОНӨҮГ	улаан	шар	шар	ногоон	шар	улаан
20	Эрдэнэт үйлдвэр ХХК	0	шар	0	0	улаан	ногоон
21	"Онги ус суваг" ОНӨҮГ	шар	шар	шар	ногоон	шар	улаан
22	"Хар хорин ус суваг" ХХК	шар	улаан	улаан	шар	улаан	ногоон
23	"Гүний ус" ХХК	ногоон	улаан	улаан	ногоон	улаан	улаан
24	"Дөрвөлж" ХХК	шар	улаан	улаан	улаан	улаан	улаан
25	"Төв чандмань ДЭХГ"	улаан	шар	шар	улаан	улаан	шар
26	"Чандмань Увс" ХХК	ногоон	шар	ногоон	ногоон	улаан	шар
27	"УСНААК" ОНӨҮГ	улаан	шар	шар	шар	улаан	улаан
28	"Хөвсгөл ус чандмань"	0	0.00	0	0	улаан	0
29	"Хэнтий ус" ХХК	улаан	улаан	улаан	улаан	ногоон	шар
30	"Багануур ус" НӨҮГ	шар	шар	ногоон	ногоон	улаан	ногоон
31	"Чандмань Налайх" НӨҮГ	улаан	шар	шар	ногоон	улаан	шар
32	"УСУГ" ОНӨҮГ	шар	улаан	ногоон	ногоон	ногоон	ногоон

ТЗЭ-ийн зардлын бүртгэлд хийсэн судалгааны үндсэн дээр зардлын шинжилгээ хийх аргачлалын төсөл боловсруулж байна.

Олон улсын нягтлан бодох бүртгэлийн зардлын бүртгэлийг ТЗЭ нь нэг загварын дагуу хөтөлдөггүйн улмаас судалгааны үр дүн буруу гарах, харьцуулалт, нэгтгэлийн явцад хүндрэл удаа дараа гарч байгаа тул Зөвлөлөөс явуулах "Санхүүгийн ажилтнуудын сургалт"-ын хөтөлбөрт зардлын бүртгэлийг төлөвлөж оруулав.

Түүнчлэн Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Улаанбаатар хот болон аймаг, орон нутагт хэрэгжсэн төслүүдийн зээл болон түүний хүүгийн эргэн төлөгдөх чадварын судалгааг байгууллага тус бүр дээр шинэчлэн боловсруулав.

3. Хүнийг хөгжүүлснээр улс хөгжинө

3.1 ТЗЭ-дийг чадавхжуулах ажлын хүрээнд

Зохицуулах зөвлөлөөс Ус хангамж, ариутгах татуургын салбарын ажилтнуудын мэдлэг, ур чадварыг чадавхжуулах зорилгоор "УХАТ-2014" сэдэвт сургалтыг Улаанбаатар хот болон хөдөө орон нутгаар бүсчилэн явуулж, ТЗЭ байгууллагуудын санхүү, инженер, техникийн ажилтнуудын дунд зохион байгуулав.

Сургалтын хөтөлбөрт "Техникийн нөхцөл олгох" журам, "Аж ахуйн харилцааны дүрэм", Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага зэрэг үйл ажиллагаанд нэн шаардлагатай дүрэм журмын танилцуулга, хэрэглээ, мөн холбогдох стандарт, олон улсад мөрдөгддөг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үйлчилгээний үнэ тарифын тогтолцоо, шинэчлэлт, зардлын хуваарилалт, усны баланс тооцох, тайлангийн маягт боловсруулах талаар мэргэжил, аргазүйн зөвлөлгөөг тусгасан.

Мөн хөтөлбөрт "Усны нөөц ашигласны төлбөр, Ус бохирдуулсны төлбөр" зэргийг зөв тооцох, зардалд шингээх, усны чанарт тавих хяналтыг сайжруулах, бохир усны цэвэрлэгээний түвшинг нэмэгдүүлэх, эрчим хүчний хэмнэлтэд дэвшилтэд техник, технологийн талаарх хичээлүүд багтав. Цуврал сургалтуудад 40 гаруй инженер, 60 гаруй санхүү бүртгэлийн ажилтнууд оролцож сертификат авлаа.

Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулдаг Нийтийн аж ахуйн салбарын мэргэшсэн инженерийн зэрэг горилох сургалтанд "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээний тусгай зөвшөөрөл, тавигдах нөхцөл, шаардлага", "Усны зүй зохистой хэрэглээ ба ус хэмнэлтийн дэвшилтэт арга хэрэгслүүд" сэдэвт хичээлийн хөтөлбөр боловсруулж хамтран ажиллав.

Зохицуулах зөвлөлөөс Ус хангамж, ариутгах татуургын салбарын ажилтнуудын мэдлэг, ур чадварыг чадавхжуулах зорилгоор зохион байгуулсан "УХАТ-2014" сэдэвт сургалтанд 40 гаруй инженер, 60 гаруй санхүү бүртгэлийн ажилтнууд оролцож сертификат авлаа.

“Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламж МОН/13/302” төслийн хүсэлтээр Өмнөговь аймгийн Зэрэг сум, Ховд аймгийн Булган сум, Өвөрхангай аймгийн Арвайхээр хот зэрэг төсөл хэрэгжсэн газруудад “Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээнд оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх бүсчилсэн сургалт” семинарт Зөвлөлийн ажлын албанаас мэргэжилтнүүд оролцон, “Хот, суурины ус хангамж,ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ” сэдвээр илтгэл тавьж, семинарт оролцогчдыг сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуургын системийн ашиглалт, үйлчилгээ, түүний онцлогийн талаар мэдээллээр хангав.

3.2 Дотоод сургалт, хөгжлийн чиглэлээр

Зохицуулах зөвлөлийн мэргэжтилтнүүд бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэх тал дээр анхаарч, англи хэл бие даан сурах хөдөлгөөн өрнүүлээд байна. Мөн 1 мэргэжилтэн бизнесийн удирдлагын магистр, 1 мэргэжилтэн доктрантурын сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд худалдах, худалдан авах А3 гэрчилгээ олгох сургалтанд 3 ажилтанг суралцуулав.

4. Ус чандмань эрдэнэ

Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний чанар, хүртээмж, үүсч буй бэрхшээл, усны үнэ цэнийг сурталчлах,усны зүй зохистой хэрэглээг олон нийтэд хэвшүүлэх зорилгоор “Mongolian Economy” сэтгүүлийн редакцтай хамтран “Цэнхэр сувдаа хайрлая” сэдэвт 1 сарын компанит аянг өрнүүлж, усыг дахин ашиглах, саарал усны тухай мэдээ, материал боловсруулж нийтлүүлснээс гадна сэтгүүлчдийг Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцуулж, тэдгээрийн өнөөгийн байдал, тулгарч буй бэрхшээлийн талаар нийтэд ил тод болгох үүднээс цуврал нийтлэл гаргахад мэргэжил арга зүйгээр хангаж ажиллав.

“Тоолууртай хэрэглээний ашиг тус”, “Ухаалаг хэрэглэж, бага төлье” сэдэвт богино хэмжээний 2D цуврал анимешныг бэлтгэж, усны зүй зохистой хэрэглээ, тоолууржилтын цуврал шторкийг

МҮОНРТ, Монгол HD, UBS телевиз зэрэг 11 телевизээр нэвтрүүлж, хөдөө, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч 20 байгууллагад хүргүүлж, орон нутгийн телевизээр нэвтрүүлэх ажлыг зохион байгууллаа.

“Хэвлэлийн эрх чөлөө” ТББ болон Өдрийн сонин, Өнөөдөр сонин, Зууны мэдээ, Үндэсний шуудан Улаанбаатар таймс зэрэг хамтран ажилладаг байгууллагууд, www.zaluu.com, www.gogo.mn, www.olloo.mn, www.ikon.mn, www.mnews.mn, www.dorgio.mn, www.society.time.mn, www.mne.mn, www.mnb.mn, www.unen.mn, www.mglradio.mn, www.photo.inet.mn, www.toim.orloo.mn, www.mongolnews.mn зэрэг цахим хуудсуудад салбарын мэдээ мэдээллийг цаг тухайд нь хангаж, Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, Монгол HD телевиз, SBN, Айст Монголия, Эх орон, Eagle зэрэг телевизээр

ярилцлага зохиож, зорилтот нэвтрүүлгүүдэд оролцов.Үүнд:

• Зохицуулах зөвлөлийн ээлжит хурлаар гарсан тусгай зөвшөөрлийн тухай шийдвэр болон Улаанбаатар хот, хөдөө орон нутагт мөрдөгдөх усны үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэн баталсан талаарх мэдээллийг цахим сайтаар зарлах, сурталчилах ажлыг зохион байгуулсан.

• Дэлхийн усны өдрийг тохиолдуулан ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаа, усны дэвшилтэт техник, технологийг олон нийтэд таниулах, мэдлэг, мэдээлэл олгох, иргэдэд ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны талаарх энгийн ойлголт, түүний үнэ цэнийг таниулах, зүй зохистой хэрэглээг хэвшүүлэх зорилгоор **“Ус-2014”** үзэсгэлэнг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сурталчлах, бодлого, үйл ажиллагааг танилцуулах, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын ажил үйлчилгээний цар хүрээ, чанар, хүртээмжийг таниулах “ХЭРЭГЛЭГЧДЭЭ СОНСЬЁ” сэдэвт Нээлттэй хаалганы өдөрлөгийн үйл ажиллагааг тус тус “Хэвлэлийн эрх чөлөө” ТББ-ын гэрээт 6 телевизээр сурталчлав.

• Нийтийн аж ахуйн холбооны “Орчин 21” сэтгүүлтэй хамтран ажиллаж, 8 удаа мэдээлэл боловсруулж нийтлүүлэв.

• Нийтийн аж ахуйн ойн хүрээнд зохион байгуулсан “Удирдах ажилтны зөвлөлдөх уулзалт”-ын явц, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлав.

5. Хамтдаа хөгжье

5.1 Гадаад хамтын ажиллагаа

Байгууллагын зүгээс төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай харилцах, үйл ажиллагаагаа олон нийтэд хүргэх, гадаадын болон олон улсын төсөл хөтөлбөртэй хамтран ажиллаж улмаар нийтийн аж ахуйн салбарт дэвшилтэт тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, салбарын инженер техникийн ажилтнуудын мэдлэг ур чадварыг дэмжих, тэргүүн туршлагыг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна. Дээрх зорилтын хүрээнд тухайн онд гадаад харилцааг өргөжүүлэн тэлэхээр WQA /Water Quality Association/ гишүүнээр элсэж харилцан туршлага солилцож байна.

Мөн олон улсын байгууллагуудаас зохион байгуулж буй ус хангамж, ариутгах татуурга, усны үйлчилгээний менежментийн чиглэлээр урт болон богино хугацааны сургалт, семинар, үзэсгэлэнд гишүүнчлэлийн хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр ТЗЭ-д болон байгууллагын инженер техникийн ажилтнуудыг хамруулав.

Үүнд:

Хүснэгт-4

3 сард Малайзын Куала Лумпур хотод зохион байгуулагдсан “Asian Water 2014” Азийн орнуудын дэвшилтэд технологи үзэсгэлэн, хуралд /ТЗУГ-ын төлөөлөгч/

3 сард Австрийн Вена хотод зохион байгуулагдсан Дэлхийн усны байгууллагын “Water loss-2014”, “Усны алдагдал” бага хурал /“Бат баян дулаан” ХХК-ийн төлөөлөгч/

9 сард Германы Илменау хотноо Илменаугийн Технологийн Их сургууль болон ДААД Боловсролын Яамнаас зохион байгуулсан “Усны нэгдсэн менежмент-2014” зуны тэтгэлэгт сургалт /“Дархан Ус суваг” ХК-ны төлөөлөгч/

9 сард WQA усны чанарын холбооноос АНУ-ын Вержиниа мужид зохион байгуулсан бага хурал /Дорноговь аймгийн “Чандмань бадрал” ХХК-ний төлөөлөгч/

11 сард Тайландын Банкок хотноо болсон “Азийн орнуудын ус хангамж, ариутгах татуургын байгууллагуудын хүний нөөцийн хөгжлийн VII чуулга уулзалт”

5.2 Дотоод хамтын ажиллагаа

БХБЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтийн газартай хамтран нийтийн аж ахуйн салбарт нэн шаардлагатай байгаа стандартын жагсаалтыг гаргаж, БХБЯ 2014 оны Нормчлолын сангийн хурлаар стандартуудыг боловсруулахаар шийдвэрлэв. Үүнд:

а."Нийтийн аж ахуйн салбарын ажиллах хүчний норм, норматив"
б."Хаягдал ус зайлуулах үйлчилгээний стандарт"

Мөн 2014 оны Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, БХБЯ-нд хүргүүлснээс гадна БХБЯ, Зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллах ажлын төлөвлөгөөг хамтран боловсруулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу ажил үйлчилгээг гүйцэтгэв. Нийслэлийн Захирагчийн ажлын албатай хамтран "УБ хотын ус хангамж... Өнөө ба ирээдүйд" сэдвээр нээлттэй хэлэлцүүлгийг Монгол улсын Ерөнхийлөгчийн Иргэний танхимд 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдөр амжилттай зохион байгууллаа.

Энэхүү хэлэлцүүлэгт Нийслэлийн захирагчийн ажлын алба, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Усны үндэсний хороо, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Ус сувгийн удирдах газар, Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар, Монголын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Монгол Улсын Усны түншлэл ТББ болон Усны салбарын төлөөлөл болох 45 төлөөлөгч оролцож, Улаанбаатар хотын ус хангамжийн одоогийн

болон ирээдүйн талаар санал бодлоо солилцлоо.

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Зохицуулах зөвлөлөөс санаачлан Нийслэлийн боловсролын газартай хамтран ЕБС-ийн сурагчдад усыг хайрлаж, зөв зохистой хэрэглэх, хэмнэх талаар мэдлэг олгох зорилгоор

"Усны ухаалаг хэрэглээ ба усны хэмнэлт" сэдвээр 40 минутын хичээлийг 2014 оны 3 дугаар сарын 21-ны өдөр Нийслэлийн 200 гаруй ерөнхий боловсролын сургуулиуд, бага, дунд, ахлан ангийн нийт 171 мянга гаруй сурагчдад заав.

Мөн "УС-2014" үзэсгэлэнг Зохицуулах зөвлөлөөс санаачлан, БОНХЯ, БХБЯ, ACF олон улсын байгууллага, УСУГ-тай хамтран 2014 оны 03-р сарын 19-21-ны өдрүүдэд зохион байгуулж, усны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 19 байгууллагыг оролцуулан усны дэвшилтэт тоног төхөөрөмж, усны хэмнэлттэй төхөөрөмжүүдийг нийтэд танилцуулж, үзэсгэлэнгийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлав.

Монгол Улсын Их хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороотой хамтран 3-р сарын 26-ны өдөр **"Ус ба тогтвортой хөгжил"** сэдэвт хэлэлцүүлгийг Төрийн ордны А танхимд зохион байгууллаа.

Монгол улсын Шадар сайд, Нийслэлийн МХГ-т хандан улсын байцаагчийн эрх авах тухай хүсэлт гаргаж, Зохицуулах зөвлөлийн ахлах мэргэжилтэнд олгов. 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдөр МХЕГ болон Зохицуулах зөвлөл хоорондын Хамтран ажиллах гэрээг байгуулав. 10-р сарын 24-ний өдөр хөдөө, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн "Удирдах ажилтны зөвлөлдөх уулзалт"-ыг зохион байгуулав. Уулзалтанд орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын нийт 36 удирдах ажилтнууд оролцсон бөгөөд Зохицуулах зөвлөлөөс байгууллагын үйл ажиллагаа, цаашдын зорилт, тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын гэрээний биелэлт,гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааг шалгасан ажлын тайлангийн талаар танилцуулж, тэдгээрийн санхүүгийн байдал, үнэ тарифын асуудлын талаар хэлэлцсэн юм. Мөн тус уулзалтаар салбарын тэргүүний байгууллагыг шалгаруулж, шагнал гардуулах үйл ажиллагаа боллоо.



Зохицуулах зөвлөлийн 2014 оны Санхүүгийн үйл ажиллагааны тайлан /мян.төг/

Эдийн засгийн ангилал	Орлого, зардлын дүн	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувиар
Ажил,үйлчилгээний орлогын дүн	482,217.00	481,674.00	99.9%
Зохицуулалт үйлчилгээний орлого	482,217.00	474,036.00	98.3%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		7,638.00	
Зардлын дүн	482,217.00	440,129.80	91.3%
Цалин,хөлс,нийгмийн даатгалын шимтгэл	284,020.00	289,312.40	101.9%
Бичиг хэрэг,шуудан холбоо,тээвэр шатахуун,	21,438.00	19,590.50	91.4%
Байрны түрээс,урсгал засвар	53,655.00	42,050.60	78.4%
Сургалт судалгаа,албан томилолт хурал,зөвлөгөөн	35,239.00	30,657.00	87.0%
Хэвлэл мэдээлэл,сурталчилгаа	14,200.00	15,100.00	106.3%
Төлбөр хураамж,бусад зардал	7,465.00	7,244.00	97.0%
Эд хогшил худалдан авах,элэгдлийн зардал	19,243.00	20,038.00	104.1%
Дотоод хөрөнгө оруулалт	46,957.00	16,138.00	34.4%
Ажиллагсдын тоо	26	22	

6. Дүгнэлт

Зохицуулах зөвлөл байгуулагдсан цагаасаа усны үйлчилгээний үнэ, тариф тогтоох, тусгай зөвшөөрөл олгох, биелэлтэд хяналт тавих чиглэлээр тодорхой ажлуудыг шат дараатай хийж, хэрэгжүүлж ирсэн билээ.

Тухайлбал үнэ,тарифын бодлогыг тодорхойлж, тогтолцоог шинэчлэн, сайжруулах талаар ажилласны үр дүнд хангагч байгууллагуудын үйл ажиллагаа сайжирч, алдагдлыг бууруулан, зарим байгууллагууд орлогоороо зардлаа нөхөж ажиллах түвшинд хүрээд байна.

Үнэ тарифыг бодит өртөг зардалд нь тулгуурлан, хамгийн бага өртгийн зарчмыг баримтлан тогтоохын тулд юуны өмнө байгууллагуудын үйл ажиллагааны зардалд хяналт тавих, үргүй зардлыг бууруулах нь чухал байдаг. Энэ зорилгоор үйлчилгээний чанар, үйл ажиллагааны үр ашгийг бодитой хэмжих гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (KPI)-ийг Англи, Америк, Австрали, болон Азийн Сингапур, Япон зэрэг улсын усны зохицуулах байгууллагуудын туршлагаас судлан нэвтрүүлэхээр тодорхой аргачлалуудыг боловсруулан 2013 оноос эхлэн туршаад байна. Үүний үр дүнд тоолууржилтын түвшинг 69 хувь хүртэл нэмэгдүүлж, орлого болоогүй ус (NRW) буюу усны зүй бус алдагдыг 31 хувь болтол бууруулсан үзүүлэлт гарлаа.

Мөн салбарын хүний нөөц, техник технологи, санхүү, эдийн засгийн үзүүлэлтийн нэгдсэн мэдээллийн санг байгуулснаар усны үйлчилгээний мэдээллийн урсгалыг оновчтой зохион байгуулах, салбарыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын бодлогыг дэмжих, улмаар түүний өгөөжийг зөв тооцох, удирдлагын менежментийн бүх түвшний ухаалаг бодлого явуулж ажиллах суурь нөхцөл тавигдлаа.

Цаашид ололт амжилтаа бататган, эхлүүлсэн ажлаа үргэлжлүүлж, усны үйлчилгээний үнэ, тарифын талаар баримтлах бодлогын баримт бичгийг олон улсын практик туршлагад үндэслэн, өөрийн орны нөхцөлд тохируулан боловсруулан гаргаж, хэрэгжүүлэхээр зорьж байна. Үүний үр дүнд олон улсын нягтлан бодох бүртгэлийн дагуу үйлдвэрлэлийн шат дамжлага бүр дээр зардлын бүртгэл хөтлөх, зах зээлийн орчинд нийцсэн зардлын индексжүүлэлтийн судалгааг явуулж, хэрэглээний түвшингээс хамаарсан, зорилтот хэрэглэгчдэд чиглэсэн блок тариф хэрэгжүүлэх туршилтыг 2015 онд хийх боломж бүрдэх юм.

Мөн Зохицуулах байгууллагын бие даасан хараат бус байдлыг хангаж, Зөвлөлийг бэхжүүлэх, үйл ажиллагааг нь тогтворжуулах, салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилт бидний өмнө тулгараад байна. Үүнийг хэрэгжүүлсний үр дүнд өмчийн олон хэлбэрт байгаа салбарын байгууллагуудын үйл ажиллагааг хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлсэн, усны үйлчилгээний менежментийн орчин үеийн арга хэлбэрүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн, хязгаарлагдмал нөөц бүхий усны зүй зохистой хэрэглээг хэвшүүлж, байгаль орчинд ээлтэй байхад чиглүүлж ажиллаж чадах юм.